



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



Implemented by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО

МБС-ын байгууллага, аж ахуйн нэгж (ААН)-үүдын хамтын үйл ажиллагааг дэмжсэн шинэлэг санаа, санаачлагыг дэвшүүлэх уралдааны удирдамж

Хамтрагчид: ХНХЯ, МБНХ, ГОУХАН (ТСМБС)

Хэрэгжүүлэгч: Монголын Барилгачдын Нэгдсэн холбоо
(МБНХ)

Зорилго: Мэргэжлийн боловсрол сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжих зорилгоор, МБС-ын байгууллага, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж (ААН)-үүдийн хоорондын тогтвортой хамтын ажиллагааг бэхжүүлсэн шинэлэг санаачлагыг дэмжихэд оршино.

2018 он

Нэг. Үндэслэл

Мэргэжлийн боловсрол , сургалт (МБС)-ын байгууллага, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж (ААН) – үүдийн хамтын ажиллагааг улам хөгжүүлэх үүднээс шинэлэг санаа, санаачлагын төслийг сонгон шалгаруулах уралдааныг зарлаж байна.

Хоёр. Төслийн нэр

Техникийн болон мэргэжлийн боловсрол , сургалтыг сайжруулах зорилгоор сургалтын байгууллага , аж ахуйн нэгжүүдын хоорондын хамтын ажиллагааны шинэлэг санаачлагыг сонгон шалгаруулах

Гурав.Төслийн зорилго

Мэргэжлийн боловсрол сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжих зорилгоор,МБС-ын байгууллага, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй (ААН)-үүдийн хоорондын тогтвортой хамтын ажиллагааг бэхжүүлсэн шинэлэг санаачлагыг дэмжихэд оршино.

Дөрөв: Хамрах хүрээ

Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол сургалтын төслийн түнш МБС-ын байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдана.

Тав. Санхүүжилт

6 хүртэлх шилдэг санаа / төслийг / сонгон шалгаруулж тус бүрийг 5000 еврогоор ГОУХАН –ээс санхүүжүүлнэ .

Зургаа. Төслийг хүлээж авах газар, хугацаа.

Хүлээж авах газар	Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Урт цагаан үйлчилгээний төв IV корпус, Идавхар Утас:+976-11-314516, 318586
Он сар өдөр	2018 оны 10-р сарын 26 -ны 17:00 цаг хүртэл
Төсөл эхлэх болон дуусах хугацаа	2018 оны 10-р сарын 26 -наас 12-р сарын 27

Долоо. Төслийн нийтлэг шаардлага

1. Төслийг 2018 оны 10-р дугаар сарын 26 -нд 17:00 цаг хүртэл МБНХ – ны байранд хүлээж авна.
2. МБС-ын байгууллага, ААН нэгжүүд хамтран сонгон шалгаруулалтанд оролцоно.
3. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй ААН нь ТСМБС-ын төслийн түнш 12 сургуулиас сонгож оролцоно.
4. Оролцох саналын үнэлгээг МБСҮТ, ГОУХАН, /ТСМБС/, МБНХ –ноос томилогдсон ажлын хэсэг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу оноогоор дүгнэнэ.
5. Үнэлгээний шалгуур үзүүлэлт бүрээр 15 хүртэлх бүхэл оноо тавина.

Найм. Төсөлд тавигдах шаардлага

1. МБС-ын байгууллага болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд нь түншлэл хэлбэрээр оролцоно
2. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй ААН-үүд нь ГОУХАН “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн түншлэгч 12 МБС-ын байгууллагуудын аль нэгэнтэй нь түншлэн оролцоно.
3. ААН, МБС-ын байгууллагуудын дэвшүүлсэн санаа санаачлага нь цаашид тогтвортой хэрэгжих боломжтойг илэрхийлсэн байна.
4. Одоогоор хэрэгжиж байгаа аливаа хамтын ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй болохыг анхаарна уу.
5. Сонгон шалгаруулалтанд оролцох төслүүд дараах мэдээллүүдийг ирүүлнэ.
 - МБС-ын байгууллага болон ААН-ын хоорондын хамтын ажиллагааг тодорхойлсон баримтууд
 - Тодорхой зорилго болон хүлээж байгаа үр дүнгээ илэрхийлэх
 - Бодит хэрэгжүүлэх хугацаа тодорхой байх
 - ААН, МБС байгууллагын оролцоотой хамтын ажиллагааны хөрөнгө оруулалт төсөв, төлөвлөгөөг ирүүлэх
 - Төслийн үйл ажиллагаа урт хугацааны тогтвортой байдлыг нотолсон баримт
 - Төслийн хугацаанд болон цаашид үйл ажиллагаа үргэлжлэх зорилтоо тодорхойлсон байх

Ес. Түншлэн оролцох боломжтой МБС-ын байгууллагууд

1. Барилгын Политехник Коллеж
2. Техник Технологийн Политехник Коллеж
3. Баянхонгор Политехник Коллеж
4. Баян Өлгий МСҮТ
5. Ховд “Хөгжил “Политехник Коллеж
6. Завхан Политехник Коллеж
7. Өмнөговь Политехник Коллеж
8. Дархан- уул аймаг дахь Уул уурхай Эрчим Хүчний Политехник Коллеж
9. Говьсүмбэр Политехник Коллеж
10. Улаангом Политехник Коллеж

11. Говь- Алтай МСҮТ
12. Дорнод Политехник Коллеж

Арав. Төслийн дэмжигдэх чиглэлийн санаа

- Ажлын байран дээр дадлагжин суралцах боломжийг нэмэгдүүлэх
- Багш, суралцагч нарт зориулсан үйлдвэрлэлийн танилцах дадлагыг боловсронгуй болгох
- Багш, ААН-ын ИТА солилцоог илэрхийлсэн байдал
- Үйлдвэрлэлийн дадлагыг бодитоор хэрэгжүүлэх төлөвлөгөө, бодит үр дүнд хүрэх
- Сургагч дадлагажигчдийн багшийн хөтөлбөрийн шинэлэг байдал
- Дадлага болон сургалтанд хэрэглэгдэх шинэ хэрэглэгдэхүүн /гарын авлага, ном, видео г.м/

Шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэх

д/д	Шалгуур үзүүлэлт	Дүгнэх үзүүлэлт	Оноо 70	
			Авбал зохих	Авсан
1	Дэвшүүлж буй шинэ санаачлагын хүрээнд хамтын ажиллагааг илэрхийлсэн байдал	Гэрээ болон бусад баримт бичиг	5	
		Төсөл хэрэгжүүлэх төсвийн тооцоо	5	
		Ажлын төлөвлөгөө	5	
Дүн			15	
2	Шинэлэг санаачлагын байдал	Оновчтой эсэх	5	
		Хэрэгжих боломж	5	
		Цаашид үргэлжлэх бодит боломж	5	
Дүн			15	
3	Төслийн үйл ажиллагааны цар хүрээ	Цаашид тогтвортой үргэлжлэхийг баталгаажуулсан тодорхойлолтууд	5	
		Нөхцөл боломж	5	
		Хэрэгжүүлэх хугацааны бодит нөхцлийн илэрхийлэлт	5	
Дүн			15	
4	Хамтран хэрэгжүүлэх байгууллага аж ахуй нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдлын үзүүлэлт	Санхүүгийн чадавхи	5	
		Хамтын ажиллагаа	5	
		Чадварын баталгаа	5	
Дүн			15	
5	Хүлээж буй үр дүн	Тогвортой хамтын ажиллагаа	5	
		Орчин бүрдүүлсэн эсэх	5	
Дүн			70	

Төсөл хүлээж авах

д/д	Төслийн нэр	ААН –МБС –ын нэр	Он сар өдөр	Гарын үсэг

Сонгон шалгаруулалтанд оролцох ААН болон МБС-ын байгууллагууд 2018 оны 10 сарын 26-ны 17:00 цаг хүртэл доорх хаягаар материалаа ирүүлнэ үү.

Хүлээн авах хаяг: Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо
Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Урт цагаан үйлчилгээний төв
IV корпус,II давхар
Улаанбаатар,Монгол Улс
Утас:+976-11-314516,318586
Факс:976-11-318685 www.buildersasso.mn